



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

Г Т.Пүрэвхатанг ажилд түр томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 01/80 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 05/13280 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Төрмөнхийн Пүрэвхатанг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Т.Пүрэвхатантай “Онцой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

